**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 06 сарын 07 өдөр Дугаар А/29 Улаанбаатар хот

“Сити тур” хотын аялал зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Сити тур” төслийг хэрэгжүүлэх тухай 47, 2020 оны 02/09, 02/10, 2021 оны 11/34 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/480, А/702 дугаар захирамж, Газрын дүрмийн 4.1.10-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Сити тур” аяллыг зохион байгуулсугай.

2. “Сити тур” хотын аяллын бэлтгэл ажлын төлөвлөгөө, аяллын маршрутыг нэгдүгээр хавсралт, хотын аялал зохион байгуулахад шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. “Хотын аялал”-ыг зохион байгуулахад шаардагдах үйл ажиллагааны зардал 7 560 000 /долоон сая таван зуун жаран мянга/ төгрөгийг “Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” арга хэмжээний холбогдох зардлаас, 395 400 /гурван зуун ерэн таван мянга дөрвөн зуу/ төгрөгийг “Сити тур” төслийн холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Өнөржаргал/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс /В.Батчимэг/-т даалгасугай.

ДАРГА Д.БАТСҮХ

1150500210

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2022 оны 06 дугаар
сарын 07 -ны өдрийн А/29 дугаар
нэгдүгээр хавсралт

# “СИТИ ТУР” ХОТЫН АЯЛЛЫН БЭЛТГЭЛ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2022.05.25 Улаанбаатар хот

| № | Хийгдэх ажил | Хугацаа | Хариуцах ажилтан |
|---|---|---|---|
| 1 | Бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргаж батлуулах, холбогдох газруудад албан бичиг хүргэх, хотын аяллыг зохион байгуулах | 2022.05.23-25 | Нийслэлийн Аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Э.Оргилцэцэг |
| 2 | Холбогдох газруудад албан бичиг хүргэх | 2022.05.16-18 | Нийслэлийн Аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Э.Оргилцэцэг |
| 3 | “Сити тур” хотын аяллын автобусны бэлэн байдал техникийн аюулгүй байдлыг хангах | 2022.05.20 | Нийслэлийн Аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Б.Ишдорж |
| 4 | Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн аялалд хамрагдсан хүүхдүүдэд хяналт тавьж ажиллах | 2022.05.23<br>2022.06.01 | Нийслэлийн Аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Э.Оргилцэцэг Т.Туул Л.Оюунхорлоо |
| 5 | “Сити тур” хотын аяллыг олон нийтэд сурталчлах, хэвлэлийн мэдээ бэлтгэх, нэвтрүүлэг бэлтгэх байгууллагатай холбогдох | 2022.05.25<br>2022.05.30 | Нийслэлийн Аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Б.Цолмонгэрэл |

## АЯЛЛЫН ХӨТӨЛБӨР-1

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтаж зохион байгуулах “Сити тур” хотын аяллын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн тусгай хөтөлбөр

| Цаг | Зохион байгуулагдах үйл ажиллагаа | Байршил |
|---|---|---|
| 08:00 - 09:00 | “Ид шидийн орон”-с аялагч хүүхдүүдээ авна. | “Ид шидийн орон” автомашины зогсоол |
| 10.00-11.00 | Монгол цэргийн музей | автомашины зогсоол |
| 12.00-13.30 | Үдийн цай / Бишрэлт ресторан/ | “Бишрэлт” зочид буудлын автомашины зогсоол |
| 13.30-14.30 | Монгол орны нутаг дэвсгэрт хэдэн сая жилийн өмнө амьдарч байсан олон төрөл, зүйлийн үлэг гүрвэлийн чулуужсан олдворуудыг үзэж эртний үеэр аялана. | |
| 16.00 | Аялагч хүүхдүүдээ “Ид шидийн орон”-д аюулгүй байдлыг хангаж хүргэж бэлэг гардуулна. | “Ид шидийн орон” автомашины зогсоол |

--- oOo ---

АЯЛЛЫН ХӨТӨЛБӨР-2

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн “Сити тур” хотын

| Цаг | Зохион байгуулагдах үйл ажиллагаа | Байршил |
|---|---|---|
| | **Налайх дүүрэг** | |
| 09:00 - 10:00 | Дүүргийн хүүхэд багачуудыг бүртгэн хамруулна. | Налайх дүүрэг |
| 11:00 – 12.00 | Монгол цэргийн музей | автомашины зогсоол |
| 12.20-13.20 | Үдийн цай ууна. /Парк ресторан/ | автомашины зогсоол |
| 14.00-15.00 | Байгалийн түүхийн музей<br>Монгол орны нутаг дэвсгэрт хэдэн сая жилийн өмнө амьдарч байсан олон төрөл, зүйлийн үлэг гүрвэлийн чулуужсан олдворуудыг үзэж эртний үеэр аялана. | автомашины зогсоол |
| 16.00 | Налайх дүүрэгт хүргэж бэлэг гардуулан өгнө. | Налайх дүүрэг |
| | **Сонгинохайрхан дүүрэг** | |
| 09:00 - 10:00 | Дүүргийн хүүхэд багачуудыг бүртгэн хамруулна. | Сонгинохайрхан дүүрэг |
| 11:00 – 12.00 | Улаанбаатар төмөр замын түүхийн музей<br>Төмөр замын түүхэн галт тэрэгнүүд болон Монгол Улсын төмөр замын үүсэл хөгжлийн тухай мэдээллийг авна. | автомашины зогсоол |
| 12.20-13.20 | Үдийн цай ууна / Holiday inn ресторан/ | автомашины зогсоол |
| 14.00-15.00 | Байгалийн түүхийн музей<br>Монгол орны нутаг дэвсгэрт хэдэн сая жилийн өмнө амьдарч байсан олон төрөл, зүйлийн үлэг гүрвэлийн чулуужсан олдворуудыг үзэж эртний үеэр аялана. /Чингэлтэй дүүргийн хүүхдийн баярын арга хэмжээ/ | автомашины зогсоол |
| 16.00 | Сонгинохайрхан дүүрэгт хүргэж бэлэг гардуулан өгнө. | Сонгинохайрхан дүүрэг |

аяллын 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн тусгай хөтөлбөр

--- оОо ---

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2022 оны 06 сарын 07 өдрийн
А/29 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

“СИТИ ТУР” ХОТЫН АЯЛАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ
ТӨСВИЙН ЗАДАРГАА

2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Улаанбаатар хот

| Д/д | Зардлын зүйл | Тоо хэмжээ | Нэгж үнэ (Төгрөг) | Нийт үнэ (Төгрөг) |
|---|---|---|---|---|
| 1 | Автобусны шатахууны зардал | 2 | 60 000*4 | 240 000 |
| 2 | Жолоочийн зардал | 2 | 150 000*4 | 600 000 |
| 3 | Хөтөч тайлбарлагчийн зардал | 2 | 150 000*2 | 600 000 |
| 4 | Өдрийн хоол | 144 хүүхэд | 15 000 | 2 160 000 |
| | Өдрийн хоол | 50 хүүхэд | 15 180 | 759 000 |
| 5 | Бэлэг | 180 хүүхэд | 19 980 | 3 596 400 |
| | Нийт | | | 7 955 400 |

--- oOo ---